



ДОРНОГОВЬ АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2017 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 94

Дорноговь аймаг, Сайншанд сум

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 25 дугаар зүйлийн 25.2, Улсын Их хурлын 2009 оны 95 дугаар тогтоолоор батлагдсан “Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого”, Засгийн газрын 2011 оны 32 дугаар тогтоолоор батлагдсан “Биеийн тамир, спортыг хөгжүүлэх цогц хөтөлбөр”, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 02/11 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн төлөө хамтдаа” аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.10.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Хөдөлгөөн эрүүл мэнд” аймгийн дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, аймгийн хэмжээнд үр дүнтэй зохион байгуулан, хэрэгжилтийн тайланг бүтэн жилээр гарган аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /Т.Энхтүвшин/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Н.Хонгорзул/, Нийгмийн бодлогын хорооны ахлагч /А.Хатансайхан/ нарт даалгасугай.

ДАРГА



С.ГҮМЭНБАЯР

0000110




“ХӨДӨЛГӨӨН-ЭРҮҮЛ МЭНД” АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого, Биеийн тамир, спортын тухай хууль, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 32 дугаар тогтоолоор батлагдсан Биеийн тамир спортыг хөгжүүлэх цогц хөтөлбөрт биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар зорилтууд дэвшүүлсэн байдаг.

Хүн төрөлхтний амьдралын хэв маягийн өөрчлөлт, мэдээлэл, техник технологийн хөгжлөөс шалтгаалан хөдөлгөөний хомстол нэмэгдэн, хүний бие бялдрын хөгжлийн үзүүлэлтүүд буурч байна.

Хүн амын бие бялдрын хөгжлийг дээшлүүлэх, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх замаар хөдөлгөөний хомстлоос шалтгаалсан өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж буй хүчин зүйлийг багасгах зөв, дадал, хэвшлийг төлөвшүүлэх зорилгоор “Чийрэгжүүлэх, бялдаржуулах үйлчилгээ” 2005:5538 стандартыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Хүн ам бие бялдрын хөгжилт, чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорил”-ын ажлыг зохион байгуулан 2017 онд нийт 6654 хүнийг хамруулсан байна. Сорилын дүнгээс авч үзвэл:



Сорилын үнэлгээнээс харахад 18-54 насныхан 60,8% идэвхтэй хамрагдсан ба үнэлгээний хувьд В,С үнэлгээтэй үнэлэгдсэн байна.

Дорноговь аймагт 2013 онд хийгдсэн бие бялдрын үзүүлэлтийн судалгаагаар 2.0% туранхай, 46.0% хэвийн, 34.2% илүүдэл жинтэй байсан ба 1-р зэргийн таргалалттай 9%, 2-р зэргийн таргалалттай нь 6.1%, 3-р зэргийн таргалалттай 2.8%, үүнээс төвийн таргалалттай 37.9% байгаа нь хүн амын дунд хөдөлгөөний ач тусыг сурталчлах, хөдөлгөөнөөр хичээллэгсдийн хүрээг өргөтгөх ажлыг зохион байгуулах шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрчээ.

Мөн сүүлийн 3 жилийн байдлаар цэргийн албанд татагдаж байгаа залуучуудын 44,6 хувь нь эрүүл мэндийн байдлын улмаас цэргийн албанд тэнцэхгүй дүн гарсан байна.

Хүн амын өвчлөл, нас баралтын шалтгаанд хүний амьдралын хэв маяг, зан үйл, дадалтай холбоотой халдварт бус өвчин давамгайлж хүн амын амьдралын чанар, дундаж наслалтад сөргөөр нөлөөлж байна.

Сүүлийн жилүүдэд хүн ам, ялангуяа хүүхэд залуучуудын дунд биеийн тамир, спортоор хичээллэх сонирхол нэмэгдэж сумдад биеийн тамир, спортын төв, талбай шинээр нэмэгдэж, хамт олон, албан байгууллагаас тодорхой санаачилга өрнүүлж, иргэдийг идэвхтэй дасгал хөдөлгөөн хийх, спортын аль нэг төрлийг сонгон авч тогтмол хичээллэхэд түлхэц болж байгаа нь эрүүл зөв амьдрах иргэдийн тоог нэмэгдүүлж байна.

Аймгийн хэмжээнд 2017 оны байдлаар 2357 хүүхэд биеийн тамир, спортоор хичээллэж байгаа ба сагсан бөмбөг, волейбол, чөлөөт бөх, жүдо бөх, үндэсний бөх, бокс, бадминтон зэрэг 8-9 төрлийн спортын дугуйлан тогтмол хичээллэж 300 гаруй хүүхэд мэргэжлийн багш, дасгалжуулагчийн удирдлага дор бэлтгэл сургуулилт хийж байна.

2015 оны 10 сараас эхлэн “Идэвхтэй хөдөлгөөн-Эрүүл амьдрал” бүх насныхан хамрагдах боломжтой өглөөний дасгалыг тогтмолжуулж уг дасгалд 70-80 хүн хамрагдсаар байна. Дасгалын дараа спортын ордонд иргэдэд ахмадын цаг, нийтийн биеийн тамирын цаг гарган бадминтон, сагсан бөмбөг, волейболын спортоор хичээллэж байна.

Аймгийн хэмжээнд 2017 оны байдлаар Сайншанд суманд БТСГ-ын спортын ордон, АШУУИС, МСҮТ, ЕБ-ийн 1,2,3,5-р сургуулийн спорт заал, Замын-Үүд сумын ЕБ-ийн сургуулиудын 3 спорт заал, Иххэт суманд 2, Зүүнбаян багт 2, бусад сумдын ерөнхий боловсролын сургуульд тус бүр 1 спорт заал, нийт 28 зааланд биеийн тамирын хичээл, нийтийн биеийн тамир, спортын арга хэмжээг явуулж байна. Энэ нь 10000 хүн амд 4 заал оногдож байна.

Хүүхэд, залуучууд, иргэдийн таргалалт, илүүдэл жин, хөдөлгөөний дутагдлын гол шалтгаанд спортын зал, танхимын хүрэлцээ ашиглалт хангалтгүй, фитнес заал, клубуудын хамрах хүрээ бага зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна. 24000 хүн оршин суудаг Сайншанд хотын хэмжээнд “Хангарьд”, “Классик жем” гэсэн 2 фитнес клуб, SS club зумба, аэробикийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байна.

Өнгөрөгч 2015 онтой харьцуулахад спортын секц, дугуйланд хамрагдаж байгаа хүүхэд залуучуудын амжилт аймаг, улс, бүс, олон улсын тэмцээнд ахиж байгаа ба өсвөр, залуучууд, насанд хүрэгчдийн ангилалд Дорноговь аймгаас өрсөлдсөн баг, тамирчид 2017 оны эхний 11 сарын байдлаар баг болон ганцаарчилсан төрөлд улс, олон хот, олон улсын чанартай тэмцээнүүдээс нийт 90 гаруй медалийг хүртээд байна.

Уг амжилт нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 10 гаруй хувиар өссөн үзүүлэлттэй ба алтан медаль 21, мөнгөн медаль 28, хүрэл медаль 41-ийг хүртээд байна.

Олныг хамарсан багийн спортын төрлүүд волейбол, сагсан бөмбөгийн төрлөөр лигийн тэмцээнийг тогтмолжуулах зорилт тавин ажиллаж аж ахуй нэгж, албан байгууллагуудын хүсэлтээр Сайншанд хотод 2017 оноос “Чансаа-2017” насанд хүрэгчдийн дунд сагсан бөмбөг, волейболын лигийн тэмцээнийг зохион байгуулж, сар бүр явагддаг уг тэмцээнд эхний 11 сарын байдлаар давхардсан тоогоор 1100 гаруй хүн хамрагдаад байна.

Биеийн тамир, спортын газраас аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа” мөрийн хөтөлбөртэй уялдуулан үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулсны хүрээнд 2017 онд аймгийн хэмжээнд улс, бүс, аймгийн чанартай спортын 66 тэмцээн явагдахаар хуваарь гарч эхний 11 сарын байдлаар 90 гаруй хувьтай хөтөлбөрийн дагуу зохион байгуулагдсан.

Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2014 оны 33-р тогтоолоор “Дугуйн хөтөлбөр” батлагдсан нь хувь хүн, гэр бүл, байгууллага хамт олонд унадаг дугуйг сурталчлах, дугуй унах хөдөлгөөн өрнүүлж, эрүүл аж төрөх дадал, зан үйлийг төлөвшүүлэх, дугуй унах орчин, нөхцөлийг бүрдүүлэх замаар нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, хөдөлгөөний дутагдал, таргалалтаас үүдэлтэй халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдлоо өгч байна.

Дорноговь аймгийн хэмжээнд дугуйн спортын мастер М.Чулуун дасгалжуулагчтай “Хулан” клуб, Сайншанд татах хэсгийн “Зүтгэх хүч” клубүүд тус тус үйл ажиллагаа явуулж одоогийн байдлаар 50 гаруй тамирчид тогтмол хичээллэж, 150 гаруй иргэн дугуйг амьдралын хэвшил болгон өдөр тутмын хэрэглэж байна.

Хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн хөрөнгөнөөс 593,2 сая төгрөгийн өртөгтэй 4,8 километр дугуйн болон явган хүний замыг дүүжин гүүрнээс цагдаагийн уулзвар хүртэл тавигдсан мөн Замын-Үүд суманд нийт 810 метр явган хүн, дугуйн зам ашиглалтад оруулсан нь иргэдийн дасгал хөдөлгөөн хийх, гүйх, дугуйн спортоор хичээллэх боломж бүрдэж байна.

Аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа” үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан нийтийн биеийн тамирыг бүх нийтийн хөдөлгөөн болгох, биеийн тамир спортоор хичээллэх, ая тухтай орчныг бүрдүүлэн дасгал хөдөлгөөнөөр хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх зорилтуудын хүрээнд иргэдийн эрүүл мэндийг спортын дасгал хөдөлгөөн, нийтийн биеийн тамираар хамгаалах, бэхжүүлэх, эрүүл аж төрөх мэдлэг дадал төлөвшүүлэхэд удирдлага, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоонд тулгуурласан цогц бодлого, үйл ажиллагаа явуулах хэрэгцээ байгаа тул “Хөдөлгөөн эрүүл мэнд” дэд хөтөлбөрийг боловсруулав.

Хоёр. Зорилго

Нийтийн биеийн тамирыг бүх нийтийн хөдөлгөөн болгож, биеийн тамир, спортоор хичээллэх, эрүүл, аюулгүй орчин нөхцөлийг бүрдүүлэн, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, дасгал, хөдөлгөөнөөр дамжуулан иргэдийг эрүүл чийрэг бие бялдартай болгоход хөтөлбөрийн зорилго оршино.

Гурав. Зорилт

Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхэд дараах зорилтуудыг дэвшүүлж байна.

Зорилт 1. Өсвөр үе, хүүхэд залуучууд, насанд хүрэгчид болон ахмад настнуудад биеийн тамир, дасгал хөдөлгөөнийг өдөр тутмын хэрэглээ болгон, идэвхийг нэмэгдүүлэх, орчин нөхцөлийг бүрдүүлэх;

Зорилт 2. Биеийн тамир, спортын чиглэлээр салбар хоорондын хамтын ажиллагааг нэмэгдүүлж, иргэд, аж ахуй нэгж, албан байгууллага, спортын холбоо, клубын оролцоонд тулгуурлан спортоор хичээллэх боломжийг бүрдүүлэх, дэмжих;

Зорилт 3. Хөдөлгөөний хомстол илүүдэл жин, буруу хооллолт, таргалалт, зүрх судасны өвчин зэрэг эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлж дундаж наслалтыг нэмэгдүүлэх;

Зорилт 4. Хөдөлгөөн эрүүл мэндийн ач холбогдлын талаар сургалт зохион байгуулах, багш дасгалжуулагч нарын мэдлэг мэргэжлийн дээшлүүлэх;

Зорилт 5. Биеийн тамир, спортын нэгдсэн мэдээллийн сантай болж, хүний нөөцийн удирдлага, төлөвлөлтийг сайжруулан, тамирчдын спортын амжилтыг ахиулах, бэлтгэх, дэмжих.

Дөрөв. Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, үр дүн

4.1. Хөтөлбөрийн 1-р зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

- 4.1.1. Иргэд, албан байгууллага, хамт олон амралт чөлөөт цагаараа биеийн тамирын дасгал хөдөлгөөн хийх, спортын арга хэмжээ зохион байгуулах спорт заал, танхим, спорт талбайн тоо хэмжээ, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх;
- 4.1.2. Оршин суугчдын хэрэгцээ, шаардлагад нийцсэн биеийн тамирын талбай, хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламж бүхий газруудыг бий болгох замаар иргэдийн дасгал хөдөлгөөн хийх орчныг сайжруулж, идэвхийг сайжруулах;
- 4.1.3. Хүүхэд залуучуудын бие бялдрыг хөгжүүлэх, тэдний нас, сонирхолд нийцүүлэн хичээлийн болон хичээлээс гадуурх сургалтын хүрээнд биеийн тамираар хичээллэх боломжийг өргөжүүлэх, биеийн тамирын хичээл, дугуйлан секцийн чанарыг сайжруулах;
- 4.1.4. Ахмад настан, албан хаагчдын дунд хийн дасгалын тэмцээн зохион байгуулан хийн дасгалыг аймгийн төв сум, багийн иргэдийн дунд дадал, хэвшил болгох;
- 4.1.5. Усан спорт сургалтын төв, фитнес клубээр хичээллэгсдийн тоог нэмэгдүүлэх, үйл ажиллагааг тогтмолжуулах, клуб, спорт холбоотой хамтарч ажиллах;
- 4.1.6. Дугуйн спортод иргэдийг уриалах, хичээллэгсдийн тоог нэмэгдүүлэх, орчин нөхцөлийг бүрдүүлэх.

4.2. Хөтөлбөрийн 2-р зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

- 4.2.1. Нутгийн удирдлага, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн оролцоо, олон улсын болон үндэсний хандивлагч байгууллагуудын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;
- 4.2.2. Бусад салбаруудын бодлого, чиг үүрэг, төсөл хөтөлбөрүүдэд иргэдийн эрүүл мэндийг дасгал хөдөлгөөнөөр дамжуулан хамгаалах, бэхжүүлэх чиг үүргийг тусгах, хамтын ажиллагааг өргөжүүлэх;
- 4.2.3. Сумд, албан байгууллагуудад чийрэгжүүлэх, бялдаржуулах танхим, кабинеттай болох аян зарлах, үйл ажиллагааг идэвхжүүлэх;
- 4.2.4. Спортын клубуудын үйл ажиллагааг идэвхжүүлэх, дэмжиж хамтран ажиллах, тэдний үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх.

4.3. Хөтөлбөрийн 3-р зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

- 4.3.1. Хөдөлгөөний хомстол, илүүдэл жин, буруу хооллолт зэрэг халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлээс зайлсхийх, иргэдэд эрүүл мэндийн зөв мэдлэгийг олгох;
- 4.3.2. Нийтийн биеийн тамир, хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийг хамгаалах, спортын нөхөрсөг тэмцээн, уралдаанаар дамжуулан эрсдэлт хүчин зүйлийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг дэмжиж идэвхжүүлэх;
- 4.3.3. Хүн амын бие бялдрын хөгжлийн түвшинг судлах, мэдээллийн тогтолцоог бэхжүүлэх;

- 4.3.4. Иргэд, албан байгууллагуудын дунд “Идэвхтэй хөдөлгөөн-Эрүүл амьдрал” өглөөний дасгал, ажлын байран дахь дасгалыг хийж хэвших, уриалга гарган хөдөлгөөний хомстлоос сэргийлэх, зааж сургах;
- 4.3.5. “Өдөрт 10000 алхалт” болон нийтийн бүжиг, явган аялал, гүйлт, дугуйн аялал зэрэг бүх нийтийг хамарсан арга хэмжээг өргөжүүлэх;
- 4.3.6. Зөв зохистой хооллолтын талаар мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах;
- 4.3.7. Архи, тамхи, мансууруулах бодисын зохисгүй хэрэглээний талаар мэргэжлийн хүмүүсийн зөвлөгөө өгөх, суртал ухуулга хийх.

4.4. Хөтөлбөрийн 4-р зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

- 4.4.1. Нийтийн биеийн тамирын арга зүй, биеийн тамирын багш нарын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэн, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;
- 4.4.2. Салбар олимпын зөвлөлтэй хамтран бүх нийтийн марафон гүйлтийн тэмцээн, авто машингүй өдөр болгон зарлаж иргэд олон нийтийг хамруулах;
- 4.4.3. Тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аймгийн төв болон сумдын биеийн тамирын багш нарт онол, практик хосолсон сургалт зохион байгуулах;
- 4.4.4. БСШУС яам болон БТСГ-аас мэргэжлийн багш, дасгалжуулагч, нийтийн биеийн тамир хариуцсан арга зүйч, мэргэжилтнийг сургагч багшаар урьж ирүүлэх, сургалт зохион байгуулах;
- 4.4.5. Бүх шатны боловсролын байгууллагын дасгал хөдөлгөөний талаар сургалт явуулах сургагч багш, эцэг эх, нийгмийн ажилтны мэдлэг чадварыг сайжруулах.

4.5. Хөтөлбөрийн 5-р зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

- 4.5.1. Дорноговь аймгийн биеийн тамир, спортын мэдээллийн нэгдсэн сантай болж, хүний нөөцийн болон барилга байгууламж, материаллаг баазын бодлого төлөвлөлтийг сайжруулах;
- 4.5.2. Сум бүрт орон тооны арга зүйчтэй болгоход удирдлага арга зүйгээр хангаж сум, багуудын хоорондын уялдаа холбоог сайжруулах;
- 4.5.3. ЕБС-ийн сурагчдын дунд спортын алдартай тамирчин, дасгалжуулагчийг урьж уулзалт, ярилцлага хийх, олимп, дэлхий, тивийн медальт тамирчдыг урьж авчран олимпизм, их спорт, үндэсний спортыг залуу хойч үед сурталчлан таниулах;
- 4.5.4. Өсвөрийн шигшээ багийн тамирчдын бие бялдар, сэтгэл зүйг спортын анагаах ухааны үндэслэлтэйгээр судлах, тамирчдын амжилтыг ахиулах бэлтгэл сургуулилтыг дэмжин ажиллах.

4.6. Хүрэх үр дүн

- 4.6.1. Эрүүл чийрэг бие бялдартай хүүхэд залуучууд, эрүүл мэндээ бэхжүүлэгч иргэдийн тоо өсөж, дасгал хөдөлгөөн хийх идэвх нэмэгдэнэ.
- 4.6.2. Биеийн тамир, спорт, дасгал, хөдөлгөөн хичээллэх орчин нөхцөл бүрдэж, салбар хоорондын уялдаа холбоо сайжирч, амжилтын чанар, хүртээмж нэмэгдэнэ.
- 4.6.3. Иргэд хүн амын эрүүл аж төрөх, хөдөлгөөнөөр дамжуулан эрүүл мэндэд ээлтэй орчин бүрдэж, халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйл болох хөдөлгөөний хомстол, таргалалт, илүүдэл жин, зүрх судасны өвчин бууран, хүн амын дундаж наслалт нэмэгдэнэ.

4.6.4. Хөдөлгөөн эрүүл мэндийн талаар өсвөр үе, хүүхэд залуучуудын эрүүл мэндийн боловсролын түвшин нэмэгдэж, биеийн тамирын багш, дасгалжуулагч нарын мэдлэг, чадвар, хандлага сайжирна.

4.6.5. Аймгийн хэмжээнд биеийн тамир, спортын чиглэлээр мэдээллийн нэгдсэн сантай болж, бодлого төлөвлөлт сайжран, тамирчдын амжилт нэмэгдэнэ.

Тав. Хөтөлбөрийн хэрэгжилтэд баримтлах зарчим.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална.

5.1. Орон нутгийн дэмжлэгт удирдлага, бусад байгууллага, салбаруудад хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр, салбар хоорондын уялдаа хамтын ажиллагаанд тулгуурлах;

5.2. МҮОХ, БТСГазар болон бусад спорт холбоод, хамтарч ажиллах албан байгууллагын санал, бодол солилцож харилцан зөвшилцөнө.

Зургаа. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

6.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн Засаг даргаар ахлуулсан Нийгмийн бодлогын хэлтэс, хөдөө орон нутагт сумын Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг хэрэгжилтэд хяналт тавьж, салбар хоорондын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулна.

6.2. Хөтөлбөрийн хэрэгжүүлэх ажлын алба нь аймгийн Биеийн тамир, спортын газар Боловсрол, соёл, урлагийн газар, Эрүүл мэндийн газар байж хэрэгжилтийг хамтран зохион байгуулж, тайлан мэдээ, мэдээллээр орон нутгийн удирдлага, бусад байгууллагуудыг хангана.

6.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг холбогдох байгууллагууд жил бүрийн төсөвтөө суулгах ба орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

Долоо. Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт

7.1. Хөтөлбөрийг 2 үе шаттай хэрэгжүүлнэ.

1 дүгээр үе шат 2018 - 2019 он.

2 дугаар үе шат 2020- 2021 он.

7.2. Хөтөлбөрийн санхүүжилт дараах эх үүсвэрүүдээс бүрдэнэ.

7.2.1. Орон нутгийн төсөв;

7.2.2. Төрийн болон орон нутгийн өмчийн холбогдох байгууллагуудын тухайн жилийн төсөв;

7.2.3. БСШУС яам, МҮОХ, БТСГ төсөл хөтөлбөрийн санхүүжилт;

7.2.4. Хуулиар хоригдоогүй бусад эх үүсвэр.

Найм. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

8.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээг жилд 1 удаа бүтэн жилээр, гүйцэтгэлийн үнэлгээг хөтөлбөр хэрэгжих хугацаанд 2 удаа аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Хяналт, шинжилгээ үнэлгээний тасаг хийнэ.

8.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад дотоодын хяналт-шинжилгээ, үнэлгээг жилд 2 / хагас бүтэн жил / удаа, гүйцэтгэлийн үнэлгээг хөтөлбөр хэрэгжих хугацаанд 2 удаа БТСГ-ын, дотоод хяналт үнэлгээ хариуцсан мэргэжилтэн, арга зүйч, шаардлагатай төрлийн дасгалжуулагч нар гүйцэтгэж мэдээлэл хэлэлцүүлнэ.

8.3. Хөтөлбөрийн хэрэгжилт тайлан, үнэлгээг аймгийн Засаг даргын тамгын газар болон Биеийн тамир, спортын газар хамтрагч талуудын албан ёсны цахим хуудас, олон нийтийн сонин, мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлнэ.

8.4. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ.

Ес. Хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Хүрэх түвшин		Мэдээ гаргах байгууллага	Хэрэгжүүлэх байгууллага
			Он	Үзүүлэлт	Он	Үзүүлэлт		
1	Биеийн тамир, спорттой холбоотой хууль эрх зүйн баримттай болох	Баримтын тоо	2017	1	2019	2	БТСГ	ЗДТГ, НБХ, БТСГ
2	Бие бялдрын сорилын үзүүлэлт хамрагдсан хүний тоо	тоо	2017	6583	2019	7000	БТСГ	БТСГ, ЭМГ, Сумдын ЗДТГ
3	Спорт заал, тоглоомын талбай	тоо	2017	Зал 28, талбай, 23	2019	Зал 30, Талбай 25	БТСГ	ЗДТГ, ХОБХ, НБХ, БТСГ
4	Нийтийн биеийн тамираар хичээллэгч, хамрагдагсдын тоо	тоо	2017	16000/	2019	19000	БТСГ	БТСГ, ЭМГ, ЕБС,
5	Секц, дугуйланд хичээллэгч өсвөрийн тамирчид	тоо	2017	2357	2019	2500	БТСГ	БТСГ,
6	Нийтийн биеийн тамир, өглөөний дасгал явагдаж буй сумдын тоо	тоо	2017	6	2019	10	БТСГ	БТСГ, Сумдын ЗДТГ, ЭМГ
7	Дугуйн зам, тамирчдын тоо	тоо	2017	Явган хүн дугуйн 4 зам /Сайншанд, Замын-Үүд/ Тамирчин (50) Хичээллэгч 150	2019	Замын тоо 6 Тамирчин 70 Хичээллэгч (200)	БТСГ	ЗДТГ, НБХ, БТСГ, Дугуйн клубууд

8	Фитнесс клубын тоо, хичээллэгсэд	тоо	2017	2/ Хичээллэгч (80)	2019	3/ (130)	БТСГ	НБХ, БТСГ, Сайншанд сум ЗДТГ
9	Иргэдийн биеийн ерөнхий үзүүлэлт	хувь	2017	20,1	2019	40	БТСГ	НБХ, БТСГ, ЭМГ сумдын эрүүл мэндийн төвүүд
10	Дасгал, хөдөлгөөнийг тогтмолжуулж нийтийн биеийн тамирыг дэлгэрүүлэх	хувь	2017	20	2019	25	БТСГ	БТСГ, Сайншанд сумын ЗДТГ, Албан байгуулла- гууд
11	Спорт, хөдөлгөөн, эрүүл мэндтэй холбоотой сургалт	тоо	2017	6	2019	10	БТСГ	ЭМГ, АШУУИС, БТСГ
12	Бялдаржуулах танхимтай байгууллагын тоо	тоо	2017	18	2019	25	БТСГ	НБХ, Сайншанд ЗДТГ, ЭМГ, Нэгдсэн эмнэлэг